

БАТЛАВ: ДГ АЙМГИЙН ШИНГЭН
ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ
ТӨҮГ-ЫН ДАРГА *Г. ГАНСҮХ*

БАТЛАВ: ДГ АЙМГИЙН "ДОРНЫН
ХАРГУЙ" ХХК-НИЙ ЗАХИРАЛ
С. ЭРДЭНЭНЭМЭХ

Зам арчлалтын гэрээ

2019 оны 03 сарын 30 өдөр

№ 2019/01002

Замын үүд сум

Энэхүү гэрээний зорилго нь гэрээлэгч гэж нэрлэгдэх "ШТШАБ" ТӨҮГ-ын дарга Галбадрах овогтой Гансүх, нөгөө талаас гүйцэтгэгч гэж нэрлэгдэх "Дорнын Харгуй" ХХК-ний захирал С.Эрдэнэнэмэх нар Замын үүд өртөөн дахь "Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж" ТӨҮГ-ын 2,2 км салаа зам, 1 ширхэг гарам, 1 ширхэг гүүр хоолой, 3 ширхэг суман шилжүүлэг, байнгын арчилгаа, засвар үйлчилгээг "Дорнын Харгуй" ХХК-тай хийж, зардлыг гэрээлэгч тал төлөх асуудлыг гэрээгээр зохицуулахад оршино.

Нэг.Ерөнхий зүйл

- 1.1 Салбар замын зааг нь Замын үүд өртөөний сум № 124-с эхлэн өргөн царигийн 20-р замаар дамжин өнгөрөх таталт тавилтын 3 зам болно.
- 1.2 Салбар замын дэлгэмэл урт нь 2200 м болно.
- 1.3 Салбар зам нь 3 ширхэг суман шилжүүлэгтэй.
- 1.4 Салбар зам нь 1 ширхэг гарам, 1 ширхэг гүүр хоолойтой.
- 1.5 Салбар зам нь "ШТШАБ" ТӨҮГ-ын балансын зам болно.

Хоёр. Ажил гүйцэтгэгч байгууллагын эрх, үүрэг

- 2.1 Салбар замын үзлэг шалгалт, арчлалтыг техник ашиглалтын дүрэм, технологийн горимын дагуу тогтмол хийх ба түүнд илэрсэн гэмтлүүдийг цаг тухайд нь засварлаж байна.
- 2.2 Салбар замаар хөдлөх бүрэлдэхүүнийг тогтоосон хурдаар явуулах нөхцлийг хангана.
- 2.3 Салбар зам арчлалтын буруугаас зөрчил гологдол гарвал гарсан хохирлыг шууд хариуцана
- 2.4 Тухайн замын техникийн паспортын бичиг баримтыг тогтмол хөтлөж уг замд орсон өөрчлөлтийг тусгаж оны эцэст жилийн үр дүнг дүгнэх үед 1%-ийг хүлээлгэж өгнө.
- 2.5 Байгалийн бэрхшээлийн үед замыг элс нөмөрлөж дардаг газрын налуулгыг тэгшилж засна.
- 2.6 Салбар зам эзэмшигч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй байх, засвар хийх нөхцөл бололцоогоор хангахгүйгээр замыг бохирдуулах, салбар зам дээр ачиж буулгаж байгаа ачааг оворгүй ачих, буулгах зэргээр галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулах, нөхцөл байдлыг бий болгосон тохиолдолд салбар замыг хаах хүртэл эрх эдэлнэ.

Гурав. Салбар зам эзэмшигчийн эрх, үүрэг

- 3.1 Төмөр замын барилга байгууламжийн овор хэмжээний дотор ямар нэгэн барилга байгууламж барих, шинээр гарам гаргахгүй байх үүргийг хүлээх ба энэ шаардлагыг хангаагүйгээс үүсэх асуудлыг бүрэн хариуцана.

ЕЮЛО017

3.2 Байгууллагаасаа төмөр зам хариуцсан ажилтанг томимлж, төмөр замтай холбогдсон ажлуудыг шуурхай шийдэх талаар хамтарч ажиллана.

3.3 Зам, сум, гармын орчинд ачаа барааны буулгалт ба ачилтаас бий болсон хогийг тогтмол цэвэрлэж, цэвэр байлгах үүргийг хүлээнэ.

3.4 Төмөр замын барилга байгууламжийн овор хэмжээ болох "С"-ын шаардлагад тохируулан ачаа барааг буулгах, мөн галт тэргэнд дайрагдаж болох зүйл зам дээр болон төмөр замын ойролцоо байлгахгүй байх, хашаан доторхи зам, сум, гармын үзлэг шалгалт, засвар үйлчилгээг хийхэд саад болохгүйгээр цэвэрлэсэн байна. /цас, мөс, хог цаас, шороо гэх мэт/ Хэрэв эдгээр шаардлагыг биелүүлээгүйгээс гарсан зөрчил болон хохирлыг салбар зам эзэмшигч байгууллага хариуцна.

3.5 Ачааг буулгаж байх үедээ замыг бүрэн бүтэн хэвийн байлгах ба гармын ховилыг дүрмийн дагуу арчилна.

3.6 Төмөр замын засвар үйлчилгээг хариуцсан байгууллагад тухайн замын дэвсгэр болон дагуу аясын зургуудын 1%-ийг бүрэн хүлээлгэж өгнө.

3.7 Салаа зам арчлалтын төлбөрийг тухайн улирлын эхний сарын эхний арван таван хоногт багтааж нэхэмжлэлээр төлнө.

Дөрөв. Хамтран хүлээх хариуцлага

4.1 Салбар зам эзэмшигч, ажил гүйцэтгэгч хоёрын аль нэгийн буруугаас галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд учирсан гологдол зөрчил гарвал түүний хариуцлага ба эд материалын хохирлыг тогтоосон актыг үндсэн дээр буруутай нь хүлээнэ.

4.2 Зам, сум, дохио тэмдэг, гармын тоноглолын бүрэн бүтэн байдлыг хашаан дотроо хариуцах ба эдэлгээний хугацаанаас өмнө үрэгдүүлбэл тухайн үед харилцан акт тавьж эзэмшигч байгууллагын захиалгын үндсэн дээр уг ажлыг "Дорнын Харгуй" ХХК гүйцэтгэж гарсан зардлыг эзэмшигч байгууллагаас нэхэмжлэн авна.

4.3 Гэрээний гүйцэтгэлийн дүнг хагас жил болон жилээр 2 байгууллагын комисс ГТХАБ-ыг хэрхэн хангасан тухай протокол бичиж гэрээг дүгнэж байх болно.

4.4 Гүйцэтгэгч замын арчилгаа үйлчилгээг зохих журмын дагуу гүйцэтгээгүй нь эзэмшигч материал нийлүүлээгүйгээс үүдэлтэй бол үүсэх үр дагаварыг хариуцахгүй.

/Энэ заалт нь гүйцэтгэгч шаардлагатай материалыг эзэмшигчид бичгээр мэдэгдсэн тохиолдолд хамаарана.

Тав. Ажлын хөлс ба тооцоо

5.1 Калькуляц нь зөвхөн замд арчилгаа, үйлчилгээ хийх зардал бөгөөд зам засварлах хэрвээ шаардлагатай бол материалын зардлыг тухай бүр нь гэрээлэгч байгууллагаар гаргуулана.

Гүйцэтгэгч
"Дорнын Харгуй"
ХХК
Төрийн захиргаа
Төрийн захиргаа

ТӨР

№	Замын байгууламжийн нэр	Нэгж	Тоо	Үнэ	Нийт дүн /төг/
1	Салаа зам	км	2.2	12 270 000	26 994 000
2	Суман шилжүүлэг	шир	3	1 550 000	4 650 000
3	Гарам	шир	1	591 000	476 000
4	ХХ-ын зардал	хүн	3	200 000	600 000
5	Дүн				32 720 000
6	НӨАТ				3 272 000
7	Нийт				35 992 000

5.2 Зам арчлалтын хөлсийг ажил дүгнэсэн протокол, замд арчилгаа хийсэн ажлын тайланг үндэслэн салаа замын байнгын арчлалтын хөлсийг салаа зам эзэмшигч нь ажил гүйцэтгэгчид улирал бүр төлж байх болно.

5.3 Зам арчлалтын хөлсийг дээрх хуваарийн дагуу улирал бүрийн эхний сарын 15-ны дотор ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу банкаар дамжуулан төлж байна.

5.4 Энэхүү гэрээний хагас жил болон жилийн үр дүнг тухайн байгууллага дээр хоёр талаас дүгнэнэ.

6. Бусад ажлын талаар

6.1 Хоёр тал гэрээ байгуулахдаа салаа замын уртыг мэргэжлийн байгууллагын батлагдсан дэвсгэр зургийг үндэслэж тодорхойлно.

6.2 Гэрээнд өөрчлөлт оруулах шаардлага гарвал энэ тухайгаа нөгөө талдаа албан ёсоор мэдэгдсэнээр гэрээний зохих заалтанд өөрчлөлт оруулана.

6.3 Урсгал засвараас бусад их ба өргөтгөлийн засвараар хийгдэх ажлыг төмөр замын ашиглалтын нормын дагуу хоёр талын актыг үндэслэн, бармтлан гарах зардлын 50%-ийн урьдчилгааг авч гүйцэтгэж байхаар тохиролцоно.

6.4 Гэрээнд заагдаагүй /үер,ус, газар хөдлөлт гэх мэт/ нэмэлт ажил гарвал харилцан тохиролцсоны үндсэн дээр уг ажлыг хийж дууссаны дара салбар зам ашиглагч байгууллага хөлсийг гүйцэтгэлийн акт, нэхэмжлэлийн дагуу төлнө.

6.5 Уг гэрээ нь 2019 оны 12-р сарын 31-ныг дуустал хугацаанд хүчинтэй байхаар гэрээг байгуулав.

6.6 Гэрээний хүчин төгөлдөр хугацаа дуусахаас өмнө 1 сарын дотор аль нэг тал нь гэрээг цуцлах талаар албан тоот бичгээр санал гаргаагүй тохиолдолд гэрээг дахин нэг жилээр сунгасанд тооцно.

Гүйцэтгэгч байгууллагын хаяг:

"Дорнын Харгуй" ХХК
Сайншанд сум 4-р баг Ганзам
гудамж 206-2 Утас:99045289

Гэрээлэгч байгууллагын хаяг:

Замын үүд сум "Шингэн түлш
шилжүүлэн ачих байгууламж"ТӨҮГ

Нэмэлт өөрчлөлт.

.....
.....